


Ус сувгийн удирдах газрын 2025 оны
...12... дугаар сарын ...24... ний едрийн
...22/35... албан бичгийн хавсралт



УЛААНБААТАР ХОТЫН УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 15

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НЭГТГЭЛ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Байгууллагын зорилго, зорилт, тайлант хугацааны ерөнхий нөхцөл байдал

Улсын болон Нийслэлийн хэмжээнд батлагдсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт

- Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан 3 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 100 хувь биелэлттэй байна.
- Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 арга хэмжээ 100 хувь биелсэн.
- Нийслэлийн Засаг даргын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 28 арга хэмжээнээс 17 арга хэмжээ хэрэгжиж, үнэлэх боломжгүй 11 арга хэмжээ байна. Үнэлгээний дундаж 98%
- Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2021–2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 21 арга хэмжээ төлөвлөж, 17 арга хэмжээ хэрэгжсэн ба гүйцэтгэл 98.2% байна.
- Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний 16 арга хэмжээ хэрэгжилтийн явц 98% үнэлэх боломжгүй 3 арга хэмжээ байна.

Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 чиглэлийн хүрээнд 119 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Улс, Нийслэлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан 43 арга хэмжээ
- Байгууллагын 2025 оны зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн 51 арга хэмжээ
- Байгууллагын хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн 18 арга хэмжээ
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад чиглэсэн 7 арга хэмжээ

Үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 100% хэрэгжүүлэн ажилласан ба улирал бүр НЗДТГазарт төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлэн ажилласан.

Дээд байгууллагуудаас ирүүлсэн 19 тогтоол шийдвэрийн хэрэгжилт дараах байдлаар хангагдлаа.

- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж 1 – 100%
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хурлын тэмдэглэл 2 – 100%
- Засгийн газрын тогтоол, хурлын тэмдэглэл 5 – 100%
- Засгийн газрын албан даалгавар 2 – 100%

- Нийслэлийн Засаг даргын захирамж 5 – 100%
- Нийслэлийн Засаг даргын хурлын тэмдэглэл 4 – 100% тус тус биелүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг сар бүр нэгтгэн хүргүүлсэн.

- Албан даалгавар 01 – 11/11 100%
- Албан даалгавар 02 – 2/2 100%
- Албан даалгавар 03 – 10/10 100%
- Албан даалгавар 04 – 5/5 100% биелсэн үзүүлэлттэй байна.

Шуурхай зөвлөгөөний үүрэг даалгаврын хэрэгжилт

- Нийслэлийн удирдах ажилтнуудын 18 удаагийн шуурхай зөвлөгөөнөөр байгууллагатай холбоотой 41 үүрэг даалгаврыг 100% биелүүлэн холбогдох маягтын дагуу <https://erp.ulaanbaatar.mn> системд онлайнаар хүргүүлж ажиллалаа.
- Байгууллагын удирдах ажилтнуудын 46 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс 393 үүрэг даалгавар өгөгдөж, хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг сар бүр Газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн нэгжийн үйл ажиллагааны гүйцэтгэлтэй уялдуулан тооцож ажиллалаа.

1.2 Удирдлагын зүгээс авч хэрэгжүүлсэн бодлого, шийдвэрүүд

Төв цэвэрлэх байгууламжид ирж буй усны бохирдол буурахгүй, хатуу хог хаягдлын хэмжээ нэмэгдсээр байгаа тул байгууллагын зүгээс 2025 оныг “Хаягдал усны бохирдол бууруулах жил” болгон зарласан.

Бүгд Найрамдах Солонгос Улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдах зөөврийн бохир ус юүлэх, урьдчилан цэвэрлэх байгууламжийг Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт барихаар шийдвэрлэн байгууламжийн загвар зураг батлууллаа.

Цэвэрлэх байгууламжийн лаг хатаах, шатаах байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Байгууллагын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан зураг төслийн нэгжийг шинээр байгуулж, ЗТ-4.4, ЗТ-10.2 чиглэлээр тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын тусгай зөвшөөрлийн хүрээнд барилгын ажил гүйцэтгэх БА-3.3, 4.3, 5.3, 6.3, 6.4 болон БА-7.1 чиглэлийн тусгай зөвшөөрлөөр шугам угсралтын дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/749 дүгээр захирамжийн дагуу Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт хэрэгжих “Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын талуудын 17 дугаар Бага хурал” төслийн хүрээнд ус хангамжийн 1,670 м, ариутгах татуургын 3,224 м шугам сүлжээг угсарч, бохир усны өргөх

насос станцыг шинээр барьж байгуулан, 42 ширхэг хяналтын худгийн угсралтын ажлыг хийж гүйцэтгэж, улсын комисс ажиллуулсан.



Сэлбэ голын далан байгуулах ажлын хүрээнд Баянмонгол хорооллын ф400мм диаметртэй шугам зөөх ажлын дагуу 232м урт шугам угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн.



Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/1518 дугаар захирамжийг үндэслэн “Бохир усны Туул-1 коллекторын угсралтын ажил гүйцэтгэх” гэрээг байгуулж, календарчилсан төлөвлөгөөний дагуу Ø1200 мм диаметртэй 120 м, Ø1500 мм диаметртэй 1,542 м урт шугам сүлжээний угсралтын ажлыг хийж гүйцэтгээд байна.



Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Тогтвортой хөгжлийн стратеги–2030” төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийх, нэмэлт өөрчлөлт, шинэчлэлт боловсруулах ажлын хэсэг томилох тухай А/107 тоот тушаалын дагуу ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын явц 90 хувьтай байна.

Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/110 дугаар тушаалаар “Байгууллагын бизнес төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах, тайлагнах, дүгнэх журам” мөн 2025 оны 07 сарын 30-ны өдрийн А/192 тоот тушаалаар сарын үр дүнгийн нэмэгдэл олгох журам, зохион байгуулалтын нэгжүүдийг дүгнэх үндсэн үзүүлэлтийг тус тус батлуулж мөрдөн ажиллаж байна.



ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Байгууллагын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай явуулах зорилгоор Газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/263 дугаар тушаалаар 2025 оны 10 дугаар сарын 16-ний өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд өвлийн горимд шилжин ажиллаж байна.

Мөн гүний худгийн ажиллах горимыг улирлын онцлогт тохируулан боловсруулж, ерөнхий инженерээр батлуулан мөрдөж ажиллаж байна.

2.1 Усны эх үүсвэрийн ашиглалт

“Ундны усны эх үүсвэрийн экологийн тэнцвэрт байдлыг хангах” зорилтын хүрээнд 4 арга хэмжээг төлөвлөж, төлөвлөгөөний биелэлтийг 100 хувьтайгаар ханган ажилласан.

Эх үүсвэрийн нийт 224 гүний худгаас өдөрт дунджаар 80–90 гүний худаг тогтмол ажиллагаатай, 112–122 гүний худаг бэлтгэл горимд, 22 гүний худаг засвартай байна.

Нэгдүгээр өргөгчийн тоног төхөөрөмжийн бэлэн байдал 90 хувь, хоёрдугаар өргөгчийн бэлэн байдал 97 хувь, дунджаар тоног төхөөрөмжийн бэлэн байдал 93.5 хувьтай байна.

Ус хангамжийн томоохон 7, жижиг 3 эх үүсвэр буюу нийт 10 эх үүсвэрээс 64.2 сая м³ (хоногт дунджаар 184.7 мян. м³) ус олборлон түгээхээр төлөвлөснөөс 66.7 сая м³ ус олборлон түгээж, шугам сүлжээнд нийлүүлсэн байна. Шахсан болон борлуулсан усны харьцаа 17.3 хувь байна.

2.2 Ус хангамжийн эх үүсвэрийн нэгдүгээр өргөгчид хийгдсэн томоохон ажлын талаар:

Төвийн эх үүсвэр, Дээд эх үүсвэр, Гачууртын эх үүсвэрүүдийн 17 гүний худгуудыг лайдаж цэвэрлэн, хөдөлгүүр насосуудыг шинээр сольж суурилуулсан.

Гачуурт эх үүсвэрийн 21 гүний худгуудын алсын удирдлагад M172 төхөөрөмж, удирдлагын самбарт зөөлөн асаалтын систем /soft starter/ суурилуулан насос хөдөлгүүрийг алсаас удирдах, анхдагч мэдээллүүдийг төв SCADA системд харах удирдах боломж бүрдсэн.



Үйлдвэрийн эх үүсвэрийн 6,7 дугаар гүний худгийг буулгаж шинээр нүхэн худаг барих ажил хийгдсэн



Гачууртын эх үүсвэрийн 1 дүгээр өргөгчийн 234м гаргалгааны шугамыг нерж шугамаар шинэчилсэн.

2.3 Цэвэр усны үйлдвэрлэл, түгээлт

Хоёрдугаар өргөгчийн тоног төхөөрөмжийн бэлэн байдал 97% байна. Насос станц, дахин дамжуулах насос станцуудад Нийт 79 насос хөдөлгүүрийн холхивчид тосолгоо үйлчилгээг графикийн дагуу хийж, хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан.

Төвийн эх үүсвэр, Үйлдвэрийн эх үүсвэр болон Баянхошуу дээд, доод, Шархад, Чингэлтэй, Хайлааст, Баруун дүүрэг зэрэг 6 дамжуулах насос станцуудын оролтын шугам дээр ф80 мм–ф800 мм сүүлийн үеийн технологи бүхий цахилгаан соронзон тоолууруудыг суурилуулсан.

Төвийн эх үүсвэрийн 6,000 В давтамж хувиргагчийн блок конденсаторын гэмтлийг засварлан хэвийн ажиллагаанд оруулсан. Давтамж хувиргагчтай ажиллах үед хоногийн цахилгааны хэрэглээ 15.4 мян.кВт, давтамж хувиргагчгүй ажиллах үед 18.0 мян.кВт байгаагаас хоногт 2.5 мян.кВт зөрүү гарч байна. Сард дунджаар 75.6

мян.кВт цахилгаан эрчим хүчний хэмнэлт үүсэж, үүнийг мөнгөн дүнгээр тооцоолбол сард дунджаар 20.0 сая төгрөгийн хэмнэлт гарч байна.



Хот байгуулалт орон сууцжуулалтын яамны санхүүжилтээр Буянт-Ухаа эх үүсвэр дээр 167/255 160кВт хүчин чадалтай насос, Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн хүрээнд баруун дүүргийн насос станцад 630/90 200кВт хүчин чадалтай насос хөдөлгүүр шинээр суурилуулсан.



2.4 Бохир ус татан зайлуулалт, цэвэрлэгээ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 73 дугаар болон 2021 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 2025 оныг “Хаягдал усны бохирдол бууруулах жил” болгон зарласантай холбогдуулан үйлдвэрүүдэд хяналт шалгалт хийх 23 ажил бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт 91%-ийн биелэлттэй байна.

Цэвэрлэх байгууламж, бага оврын цэвэрлэх байгууламж, бохир усны өргөх насос станцуудын ажиллах горимыг Газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/263 тоот тушаалаар батлуулан 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд өвлийн горимд шилжүүлэн мөрдөн ажиллаж байна.

Цэвэрлэх байгууламжууд 71.36 сая.м³ бохир ус татан зайлуулахаар төлөвлөснөөс ХБГүйцэтгэлээр 69.44 сая. м³ бохир ус татан зайлуулсан. Үүнээс 3.58 сая.м³-ийг шинэ төв цэвэрлэх байгууламжид хүлээн авч цэвэрлэсэн.

Бохир усны төв болон салбар шугам, ОСНААУГ, тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд, эмнэлэг, оюутны байр, үйлдвэрийн газруудын бохир усны цуглуулах

худагт нийт 264 шүүр суурилуулж хэрэглэгчдэд хүлээлгэн өгсөн. Шүүр суурилуулсан худгийн байршлыг Google Earth-д тэмдэглэн GIS программд оруулан, шүүрэнд тунасан хатуу хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.



Олон нийтийн хандлагыг өөрчлөх зорилгоор “Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлье” уриалгыг дэвшүүлж, 38 төрлийн видео шторкийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн. Мөн “Суултуур — хогийн сав биш” сэдэвт 5,000 ширхэг зурагт хуудсыг үзвэр үйлчилгээний газруудын ариун цэврийн өрөөнд байршуулан ажилласан.

Зөөврийн бохир ус нийлүүлдэг 4 цэгт хяналт шалгалт хийж, зөвшөөрөлгүй 65 ширхэг бохир ус зөөврийн машиныг бүртгэн, бохир ус нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн Байгаль орчны газар болон Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн удирдамжийн дагуу бага оврын цэвэрлэх байгууламжгүй 50 үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, орон сууцны нийтийн аж ахуйн удирдах газрын дамжин 10 машин угаалгын газар, цуглуулах шугамын 26 худгийг хамарсан хамтарсан хяналт шалгалт явуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Хан-Уул дүүргийн 19, 20 дугаар хороонд байрлах арьс шир, ноос ноолуур боловсруулах 10 үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, MNS 6561:2024 стандартын шаардлага хангаагүй үйлдвэрүүдэд албан шаардлага хүргүүлсэн.



Урьдчилан цэвэрлэх байгууламж 194.9 мян.м³ бохир ус хүлээн авч, механик болон химийн цэвэрлэгээ хийн 70.6%-тай цэвэрлэн шугам сүлжээнд нийлүүлж байна. Лаг усгүйжүүлэгчээс 39396м³ шингэн лагийг хүлээн авч усгүйжүүлэн, 55-60% чийгшил бүхий 963.4 тн лагийг цэвэрлэх байгууламжийн лагийн картад буулгасан.

Төв цэвэрлэх байгууламжийн лаг усгүйжүүлэх байгууламж нь 94–96 хувийн чийгшилтэй 296,130 м³ түүхий лагийг хүлээн авч усгүйжүүлэн, 73–75 хувийн чийгшилтэй 23,372 м³ лагийг картад буулгасан. Мөн хог шүүх шүүрээр нийт 409.4 тонн хог шүүн авснаас 13.7 хувь буюу 6.5 тонн нь үс, хялгас, ноос болон механик хог хаягдал байна.



Морингийн цэвэрлэх байгууламжийн лаг өтгөрүүлэгч санг лайдаж 195 тн лаг, 350 кг үс ноос цэвэрлэж ачиж зайлуулсан.

Яармаг-2 бохир усны өргөх насос станцын хүлээн авах сангийн лайдах ажлыг 11 дүгээр сарын 06–08-ны өдрүүдэд хийж гүйцэтгэн, хүлээн авах санд хуримтлагдсан 55 тонн хог хаягдлыг цэвэрлэн, хэвийн ажиллагаанд оруулсан.



Яармаг-1 бохир усны өргөх насос станцын насосны ажлын бүтээмж буурч, гүйдлийн ачаалал (ампер) багассантай холбогдуулан сар шинийн баярын өдрүүдэд тэг зогсолт хийж, хүлээн авах сангийн лайдах ажлыг эхлүүлсэн. Уг ажлыг 55 цагт хийж гүйцэтгэж, станцыг хэвийн ажиллагаанд оруулсан. Хүлээх авах сангийн түвшингийн зөрүүтэй хаягдмал шугамыг үндсэн сорох шугамтай холбож Ф-200мм таслах хаалт шинээр суурилуулсан.



Яармаг-1 бохир усны өргөх насос станцыг тэг зогсоох үед цуглуулах шугамын хальсан бохир ус хөлдөж, 40,000 м² талбайд мөс тогтсон. Үүссэн мөсийг ховхолж, ачиж зайлуулах ажлыг “Хан Эко тохижилт үйлчилгээний газар”-тай хамтран зохион

байгуулж, нийт 2,700м³ гаруй мөсийг ачиж зайлуулсан. Мөн ойр орчмын талбайд гипохлоритын уусмалаар ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



2.5 Цэвэр, бохир усны чанарын хяналт

Ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөнд ус хангамжийн чиглэлээр 41, ариун цэврийн байгууламжийн чиглэлээр 13, хяналт, баталгаажуулалт, сургалт, сурталчилгааны чиглэлээр 23, нийт 77 ажил тусгагдсан ба төлөвлөгөөний биелэлт 90%-тай байна.

Цэвэр усны нийт 4600 сорьц авахаар төлөвлөж, нийт 5164 сорьц авснаас ус хангамжийн эх үүсвэрүүд, дамжуулан шахах насос станц, усан сан, ус түгээх байрууд болон хэрэглэгчийн шугам сүлжээнээс 4600 (ХБГ) төлөвлөгөөт сорьц, төлөвлөгөөт бус 564 сорьцыг авч зохих үзүүлэлтүүдийн дагуу шинжлэн, үр дүнг тухай бүрд мэдээлэн ажилласан бөгөөд шинжилгээний дүнгээр хэрэглэгчдэд түгээж буй унд, ахуйн ус нь MNS 0900:2018 стандартын шаардлагад нийцэж байна.

Ус түгээх байрны усан сангийн 715 угаалга, тээврийн хэрэгслийн 138 угаалга, давтан 40 удаагийн угаалга халдваргүйжүүлэлт хийж ажиллалаа.

Бохир усны нийт 1948 сорьц авахаар төлөвлөж, 2380 сорьц авснаас төлөвлөгөөт 1948 сорьц (цэвэрлэх байгууламжуудаас 615, үйлдвэр аж ахуйн газруудаас 1149, Туул гол дагуух цэгүүдээс 24, ариутгах татуургын төв шугам дагуух цэгүүдээс 160), төлөвлөгөөт бус 432 сорьц авч зохих үзүүлэлтүүдийн дагуу шинжлэн, үр дүнг тухай бүрд мэдээлэн ажиллалаа.

Төв цэвэрлэх байгууламж нь хүлээн авах хүчин чадлаас 388-1140 мг/л-ээр их бохирдолтой хаягдал ус хүлээн авч байгаа нь механик болон биологи цэвэрлэгээнд сөргөөр нөлөөлж цэвэрлэгдээд гарч байгаа усны чанар нь MNS 4943:2015 стандартын шаардлагад нийцэхгүй байна.

Хүснэгт 1. Төв цэвэрлэх байгууламжид хүлээн авч буй бохир усны бохирдлын хэмжээ

Бохирдлын үзүүлэлт	MNS 6561:2024 мг/л	Дундаж мг/л	Стандартаас
Умбуур бодис	400	1177	777
БХХ ₅	400	809.8	388
ХХХ	800	2020	1140

Хүснэгт 2. Төв цэвэрлэх байгууламжаас гарч буй усны чанар

Бохирдлын үзүүлэлт	MNS 4943:2015 мг/л	Дундаж мг/л	Стандартаас
Умбуур бодис	30	94.5	64.5
БХХ ₅	20	135.6	115.6

XXX	50	376.8	326.8
-----	----	-------	-------

Төв цэвэрлэх байгууламжид хүлээн авч байгаа бохир усыг 79.5%, бага оврын цэвэрлэх байгууламжуудад хүлээн авч байгаа бохир усыг дунджаар 95%-тай цэвэрлэн байгальд нийлүүлэхээр төлөвлөснөөс Төв цэвэрлэх байгууламж дунджаар 81.3%, бага оврын цэвэрлэх байгууламжууд дунджаар 96.6%-тай цэвэрлэн байгальд нийлүүлж байна.

2.6 Хэрэглэгчийн тоо, үйлчилгээний чанар

Байгууллага нь 2025 онд “Үйл ажиллагааны төрлийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах” зорилтын хүрээнд 5, Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр 7, нийт 12 ажлыг төлөвлөсөн бөгөөд 12 ажлыг 100%-тай, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн хүн амыг ундны усаар тасралтгүй хангах, гарсан бохир усыг татан зайлуулж цэвэрлэн байгальд нийлүүлэх үндсэн үүргийн хүрээнд нийт 7435 хэрэглэгчтэй цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах гэрээ байгуулан ажиллаж байна. Гэр хороололд шугамын 328, зөөврийн 378 ус түгээх байраар иргэдэд үйлчилж байна.

Усны тоолуурын лабораторид тайлант хугацаанд 6647 тоолуур баталгаажуулах төлөвлөгөөтэй ажилласнаас 6971 тоолуур хүлээн авч шалгасан ба тоолуур баталгаажуулах, шалгах үйл ажиллагаанаас байгууллагад 164.1 сая төгрөгийн орлого оруулан ажиллалаа.

Хэрэглэгчийн хүсэлтийн дагуу 115 хэрэглэгчийн бохир усны 541 худаг болон дундын эзэмшлийн шугам сүлжээний угаалгыг Шугамын ашиглалт, угсралт, засварын албатай хамтран төлбөр үйлчилгээгээр хийсэн.

Нийслэлийн төвлөрсөн системд холбогдсон орон сууцны айл өрхийн нэг хүний хоногийн хэрэглээ 116.5 л/хон, зөөврийн ус түгээх байраар үйлчлүүлж буй нэг хүний хоногийн хэрэглээ 8.0 л/хон, шугамын ус түгээх байраар үйлчлүүлж буй нэг хүний хоногийн хэрэглээ 10.4 л/хоног байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг баримтлан нийт 1294 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд 1285 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж ажиллалаа. Үүнд:

Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв	- 477 /37.1%/
Байгууллага	- 583 /45.4%/
1800-1200 тусгай дугаар	- 24 /1.8%/
Засгийн газрын 11-11 төв	- 200 /15.5%/
E-service	- 3 /0.2%/ байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 4 цаг 47 минут байна.

Цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөл гаргуулах болон сунгуулах, цэвэр, бохир усны шугамын холбох цэг өөрчлүүлэх 1600 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын материалыг хүлээн авч техникийн нөхцөл олгох комиссын 16 удаагийн хурлаар хэлэлцүүлж, хурлын шийдвэрийн дагуу 600 иргэн, аж ахуйн

нэгжид техникийн нөхцөл олгож, 575 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад албан бичгээр хариу хүргүүлсэн. Техникийн нөхцөл олгох хурлын шийдвэрийг тухай бүрд нь байгууллагын веб сайтад байршуулж, хэрэглэгч нарт мэдээлэл хүргэн ажиллалаа.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн хүсэлтийн дагуу нийт 467 инженерийн шугам сүлжээний ажлын зураг зөвшилцсөн ба үүнээс

- хэрэглэгчийн ажлын болон кадастрын зурагт шугамын тодруулга 46,
- цэвэр, бохир усны гол шугамын ажлын зураг 16,
- барилгын гадна ус хангамж, ариутгах татуургын ажлын зураг 257,
- бусад инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажлын зураг 148 байна.

2.7 Тоног төхөөрөмжийн ашиглалт, цэвэр, бохир усны шугам сүлжээний засвар үйлчилгээ

Цэвэр усны Ø150–Ø900 мм диаметртэй 586 км шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээг 10 бригад, бохир усны Ø150–Ø1400 мм диаметртэй 235.6 км шугам сүлжээ болон 4,120 ширхэг үзлэгийн худгийн ашиглалт, үйлчилгээг 7 бригад хариуцан, өдөр тутмын шугам эргэлтийн графикийн дагуу хяналт тавьж, их болон урсгал засварын ажлыг гүйцэтгэн ажиллаж байна. Засварын ажлын төлөвлөгөөний дагуу ф50-400мм-ийн голчтой 34 хаалтыг шинээр солих, 16 галын гидрант, цэвэр бохир усны 171 худагт шат суурилуулсан.

Нийслэлийн 4 дүүргийн 4 байршилд ф250-400мм хүртэлх диаметртэй 1396 метр шугам хоолойг шуудуугүй технологиор доторлож шинэчилсэн. Үүнд:

2025 онд цэвэр усны Ф250-500мм хүртэлх диаметртэй 1652м шугамыг доторлохоос 1396м шугам Close-Fit болон CIPP технологиор доторлосон.



БГД 3.4 хороолол ф300мм шугам 1100м доторлохоос 1025м шугам доторлосон



ЧД Гэсэр ф400мм шугам 33м доторлохоос 28 м шугам доторлосон.



БЗД Сансарын туннелийн урд ф300мм шугам 92м доторлохоос 91м шугам доторлосон.



ХУД 3ДТГ-ын хойд хэсэг ф250мм шугам 260м доторлохоос 252м шугам доторлосон.

Хавар, намрын төлөвлөгөөт шугам угаалгын ажилд 1198 худгийн 54822м шугамыг КО-502Б, КО-600 автомашинаар буудуулж цэвэрлэсэн мөн 2568 худагт гар цэвэрлэгээ хийсэн.

Бохир ус тээвэрлэн нийлүүлдэг ХМК-500, Төвийн 1200, Туул-1, Налайхын ф500мм-ийн коллектор дахь цэгүүдэд 7 хоног бүр тогтмол цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажиллалаа.



Цэвэрлэх байгууламжуудын 139 ширхэг насос, тоног төхөөрөмжийн үзлэг үйлчилгээ, их болон урсгал засварын ажлыг батлагдсан төлөвлөгөө, графикийн дагуу зохион байгуулж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг 98%-тай байна. Насос, тоног төхөөрөмж, хаалт, шугам хоолойд гарсан 154 удаагийн гэмтэл саатлыг түргэн шуурхай засварлан ажиллалаа.

Шинэ захын насос станцын 3-р сараалжийн гол хугарч гинж доод дамраас мултарсныг сараалжийг сувгаас гарган засварлаж хэвийн ажиллагааг хангасан.



Центрфуг болон лаг шахах шугам сүлжээнд ашиглалтын явцад хог хаягдал орж бөглөрч байгааг тухай бүрд задалж цэвэрлэн хэвийн ажиллагаанд оруулсан.

Түүхий үлдэцийн насос станцын 3,4-р тунгаагуурын фермийн дугуй салсныг бэлтгэл дугуйгаар сольж ажиллуулсан.



Баруун сараалжийн 1 дүгээр сараалжийн гинж тасарч холхивчны гадар үүр хагарч зогссон тул сараалжийг сувгаас гарган шалгахад бетоны хагархай болон төмөр орж гацаан доод гинж дамраас мултарч 17 ширхэг гол хугарсныг засварлаж ажиллалаа.

Урьдчилан цэвэрлэх байгууламжийн насос тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахын тулд графикийн дагуу үзлэг үйлчилгээг хийж, нийт 39 тоног төхөөрөмжийн жигд ажиллагааг ханган ажиллаж байгаа бөгөөд насос тоног төхөөрөмж, шугам хоолой, хаалтад 76 удаагийн гэмтэл саатал гарсныг тухай бүрд нь засварлаж хэвийн болголоо.

Сараалжийн байгууламжийн суваг, сульфид, хромын хүлээн авах сан, эздүүлэх станц, хромын эздүүлэх 200м³ сан, 3-р тунгаагуурын лаг буудаж цэвэрлэх ажил хийгдсэн.



Байгууллагын хэмжээнд 151 автомашин, механизмуудын бэлэн байдлыг ханган ажиллаж байгаа бөгөөд машин, механизмын техникийн бэлэн байдал 93.4%-тай, парк ашиглалт 78.6%-тай байна.

2.8 Байгууллагын худалдан авах ажиллагаа, хяналт шалгалт

Байгууллагын хэмжээнд шинэ техник технологи, барилга байгууламжийн их ба урсгал засварын төлөвлөгөөнд нийт 369 нэр төрлийн 16.9 тэрбум төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 316 нэр төрлийн 13.8 тэрбум төгрөгийн ажил хийгдэж төлөвлөгөөний биелэлт 85.6% тендер амжилтгүй болсон 36 нэр төрлийн 1.29 тэрбум төгрөг байна.

Байгууллагын үйл ажиллагааг хэвийн найдвартай явуулахын тулд 2025 оны хөрөнгө оруулалт, их ба урсгал засварын төлөвлөгөөнд тусгагдаагүй нэмэлтээр хийгдэх зайлшгүй шаардлагатай 20 нэр төрлийн 290.76 сая төгрөгийг газрын даргын тушаалаар магадлашгүй ажлын зардлаас гаргаад байна.

Нийслэлийн Засаг Даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/1518 дугаар захирамжийн дагуу манай байгууллага нь “Бохир усны Туул-1 коллекторын байгууламжийн ажил гүйцэтгэх” НҮЦХ/2024-А/1518 дугаартай гэрээг байгуулан тухайн шугам сүлжээг угсрах ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж байна. Тухайн ажлын хүрээнд сонгон шалгаруулалтуудыг хийж, гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн Засаг Даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/749 дугаар захирамжаар манай байгууллага нь Нэгдсэн Үндэстний байгууллагын “Цөлжилттэй тэмцэх тухай” суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын байгууламжийн Багц-3 “Гадна инженерийн шугам сүлжээний ажил, ус хангамж ариутгах татуурга, усалгааны систем” хийх ажлыг гүйцэтгэхээр болсон. Энэ ажлын хүрээнд сонгон шалгаруулалтуудыг хийж, гэрээ байгуулан ажиллаж байна.

Байгууллагын хэмжээнд 2025 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 29 нээлттэй тендерийн 252 багц сонгон шалгаруулахаас 29 тендерийн 222 багцад

гэрээ байгуулж, үнийн харьцуулалтын аргаар 3 төрлийн 4 багц сонгон шалгаруулахаас 3 төрлийн 4 багцад гэрээ байгуулж, шууд гэрээ байгуулах аргаар 3 тендерийн гэрээ байгуулан ажиллалаа. Шууд худалдан авалтын төлөвлөгөөний дагуу нийт 44 төрлийн худалдан авалт хийгдэхээс 41 худалдан авалт хийгдэж, гүйцэтгэл 93.2%-тай байна.

2025 онд гүйцэтгэгч, нийлүүлэгч нараас нийт 204 комисс ажиллуулах хүсэлт албан тоотоор ирүүлснээс 185 комиссыг ажиллуулсан. Үүнээс комиссын акт үйлдсэн 124, комиссын гишүүдээс үүрэг даалгавар өгсөн 61, комисс ажиллуулахаар хүлээгдэж буй үлдэгдэл 19 байна.

Засгийн Газрын 2011.11.09-ний өдрийн “Нийтлэг журам батлах тухай” 311 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023.07.03-ны өдрийн А/727 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”, байгууллагын даргын 2023.11.23-ны өдрийн А/283 дугаар тушаалаар батлагдсан “Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”, 2025.05.02-ны өдрийн А/111 дүгээр тушаалын 12 дугаар хавсралтаар батлагдсан “Дотоод хяналтын нэгжийн дүрэм”-ийг тус тус үндэслэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна.

Байгууллагын үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааны горимын хэрэгжилт, байгууламжийн хэвийн, тасралтгүй ажиллагааг хангуулах зорилгоор удирдамжтай хяналт шалгалтыг 7, ажлын бус цагийн хяналт шалгалтыг 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 34 зохион байгуулалтын нэгжийн 88 цэг салбарыг хамруулсан.

Засгийн Газрын 53 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах дэд ажлын хэсгээс гаргасан төлөвлөгөө, удирдамжийн дагуу төвийн ариутгах татуургын шугам сүлжээний 35 цэгээс нийт 99 сорьц авч шинжилгээний дүн шинжилгээнд хяналт тавьж ажиллалаа. Сорьц авсан цэгүүдийг байршлыг GIS системд бүртгэсэн.

Зохион байгуулалтын нэгжүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжүүддээ аюулгүй ажиллагааны зааврыг батлагдсан загварын дагуу байршуулсан эсэхэд ХАБЭА-н мониторингийн үзлэг шалгалтаар хяналт тавьж, шаардлагатай зөвлөмжийг өгч тухай бүрд нь арилгуулж ажиллалаа.

Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/1220 дугаар захирамжийн дагуу явагдсан Төрийн ажлын зохион байгуулалт, Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор байгууллагын комиссыг Захиргаа удирдлагын хэлтсийн даргаар ахлуулан байгуулж, 38 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж, улсын үзлэгээр 91 хувь буюу бүрэн хангалттай гэж дүгнэгдсэн.



2.9 Ослын гаралт, шуурхай арга хэмжээ

Хяналт удирдлагын төвд инженерийн шугам сүлжээтэй холбоотой дуудлага 100, мэдээлэл лавлагаа хүссэн дуудлага 5420, УТУТ-тай холбоотой дуудлага 19636, гомдол 5 хүлээн авч 1-8 цагт багтаан барагдуулан ажилласан. Ирсэн дуудлагуудыг Хэрэглэгчтэй харилцах харилцааны менежментийн системд ангилан бүртгэсэн.

Төлөвлөгөөт засварын ажлын үеэр ус хангамжийг түр хязгаарлах тухай мэдээллийг 4700 хэрэглэгчид мессежээр хүргэсэн. Мөн орон сууц, эмнэлэг, томоохон үйлдвэр, Элчин сайдын яамд зэрэг онцгой ангиллын байгууллагуудад утсаар урьдчилан мэдээлэл өгч ажилласан.

Цэвэр усны төв шугамд 29, хэрэглэгчийн салбар шугамд 35 гэмтэл гарсныг шуурхай засварлан хэвийн ажиллагаанд оруулсан. Мөн ариутгах татуургын коллектор болон салбар шугамд гарсан 41 удаагийн бөглөрөл, 46 удаагийн тунааг арилгаж, шаардлага хангахгүй 87 худгийн тагийг шинэчилсэн.



Өвөлжилтийн бэлэн байдал хангуулах Ерөнхий инженерийн нэрэмжит үзлэгийг удирдамжийн дагуу 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрүүдийн хооронд 1 сарын хугацаатай 13 зохион байгуулалтын нэгжид зохион байгуулсан. Үзлэгийн тайлан, үр дүнг нэгтгэн Даргын зөвлөлд оруулан саналыг тусган, үзлэг шалгалт хийж, ажил сайжруулах хугацаатай үүрэг даалгаврыг 462 ажил бүхий зөвлөмжөөр өгөн хэрэгжилтийг хангуулж, гүйцэтгэлийн хяналтыг 5 зохион байгуулалтын нэгжийн 54 цэг салбарт хийж ажилласан.

Байгууллагад тайлант хугацаанд 2025.11.30-ны өдрийн байдлаар edoc.ub.gov.mn цахим программаар 4708 албан бичиг ирсэн байна. Үүнээс хариутай албан бичиг 1321 ирсэн байна. Үүнээс хариуг хугацаанд нь шийдвэрлэсэн 1295 албан бичиг, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 6, судалж байгаа 20 албан бичиг байна. Нийт 4668 ирсэн бичгийн шийдвэрлэлтэд хяналт хийж, хаалтыг баталгаажуулсан.

Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 99.7%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь 99.7% буюу дундаж хугацаа 6.22 хоног, индекс 0.3986 буюу "B" үнэлгээтэй байна.

2.9 Цахилгаан хангамж, автоматжуулалт

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан инновац бүхий техник, технологийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд 3 ажил төлөвлөж төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай байна.

Байгууллагын хэмжээнд 77.39 сая кВт.ц цахилгаан эрчим хүчний зарцуулах төлөвлөгөөтэй ажилласнаас гүйцэтгэлээр 72.45 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг хэрэглэж, бодит дүнгээр -4.9 сая кВт.ц буюу 6.3%-иар хэмнэж ажилласан бөгөөд мөнгөн дүнгээр 23800.2 сая төг төлөвлөгөөтэй ажилласнаас 22229.9 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 1570.3 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллалаа.

Өмнөх онд 1м³ ус олборлон түгээхэд 0.65кВт, 1м³ бохир ус татан зайлуулж цэвэрлэхэд 0.33кВт зарцуулж байсан бол 2025 онд 1м³ ус олборлон түгээхэд 0.64кВт, 1м³ бохир ус татан зайлуулж цэвэрлэхэд 0.34кВт цахилгааны чадал зарцуулан хэмнэлттэй ажиллаа.

Байгууллагын эзэмшилд байгаа нийт 107 дэд өртөө, 85 хуваарилах самбар, 79км цахилгаан дамжуулах агаарын шугамд засвар үйлчилгээг хийж цахилгаан тоноглол, генераторын хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа

Нийт 224 гүний худгийн барилга, Төв болон морингийн цэвэрлэх байгууламж, 297 ус түгээх байранд газардуулгын эсэргүүцлийг хэмжилт хийсэн. Газардуулгын эсэргүүцэл хэвийн зөвшөөрөгдөх хэмжээнд байсан тул протокол үйлдэж дүгнэлт гаргаж ажиллалаа.

Цахилгаан хангамжийн 10кВ-ын кабель шугамд нийт 8 муфьт, 4 тулгуурт намгийн хамгаалалт, 20 тулгуурт тусгаарлах изолятор сольсон, 55, 140кВт-ын 2 хөдөлгүүр ороолгосон, 12 тулгуурыг тэгшилж хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.



Шугамын болон зөөврийн ус түгээх байруудын цахилгаан хангамжийн тоноглолд нийт давхардсан тоогоор 1353 удаагийн засвар үйлчилгээ хийсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд автоматикийн тоног төхөөрөмжтэй холбоотой нийт 85, нэг цэгийн тоолуурын системийн 96, GPS 241, ус түгээх ухаалаг төхөөрөмжид 276 тохиргоо, 64 засвар үйлчилгээ хийж ажиллалаа.

Цэвэр усны шугамын хяналтыг цэгүүдэд нарны эрчим хүчний системээр тоноглох ажлыг хийсэн.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮ, ТӨСӨВ

2025 онд “Санхүүгийн тогтвортой байдлыг ханган ажиллах” зорилтын хүрээнд нийт 5 арга хэмжээг төлөвлөснөөс 4 арга хэмжээг 100 хувьтайгаар хэрэгжүүлсэн. Үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ байгаа бөгөөд төлөвлөгөөт ажлуудын хэрэгжилтийг дунджаар 80 хувьтай ханган ажилласан.

3.1. Орлого, зарлагын тайлан

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1498, 2024 оны А/1293, 2025 оны 2025 оны А/85, А/498, А/802, А/1308 дугаар захирамжаар 24431.0 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгалаа.

Хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 134908.1 сая төгрөгийн орлого олохоос 134671.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, биелэлт 99.8% байна. Мөн 173552.6 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал төлөвлөснөөс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 159051.8 сая төгрөгийн зардал гаргаж, 14500.8 сая төгрөг хэмнэн ажиллах төлөвтэй байна.

Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2025 оны А/75, А/248, А/107, А/248, дугаар тушаал, 2024 оны Нийслэлийн Засаг даргын А/1275, А/1276, 2025 оны А/645, А/988, А/645 дугаар захирамжийг үндэслэн 3357.2 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлээс хасаж ажиллалаа.

Байгууллага нь гэнэтийн ослын даатгалд 1670 ажилтан 16.2 сая төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалд 157 ажилтан 3.4 сая төгрөг, эд хөрөнгийн даатгалд 1 ажилтан 0.02 сая төгрөг, нийт давхардсан тоогоор 1828 ажилтныг 19.6 сая төгрөгийн даатгалд хамруулсан.

Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан журмын даатгалд 140 машиныг 38.3 сая төгрөг, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд 147 ажилтныг 17.2 сая төгрөгийн даатгалд хамруулж, Ард даатгал ХХК-тай байгуулсан гэрээний дагуу төлбөрийг шилжүүлсэн.

3.2 Төсөвт өртөг, хэрэгжилт

Тайлант хугацаанд 2025 оны хөрөнгө оруулалт, их урсгал засварын төлөвлөгөөний дагуу 142 тоо хэмжээний 14323.8 сая төгрөгийн гэрээ, 29 ажлын 3963.4 сая төгрөгийн хяналтын төсвийг хянаж, 328 бараа, ажил, үйлчилгээний 12783.4 сая төгрөгийн санхүүжилтийг шилжүүлж ажиллалаа.

2025 оны бараа материалын захиалгын төлөвлөгөөний дагуу 189 худалдан авалтын 34536.4 сая төгрөгийн гэрээг хянасны 17735.3 сая төгрөг нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны ТИЭНХО олон улсын худалдаа ХХК-тай хийсэн шилээр бэхжүүлсэн элсэн сэндвичэн хоолой худалдан авах гэрээ байна. Мөн бараа материалын захиалгын дутуу 456 удаагийн 15824.3 сая төгрөгийн сэлбэг, материалын нэхэмжлэхийг хянаж санхүүжүүлэв.

Оны эхэнд Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороотой тооцоо нийлсэн акт үйлдэж 802.3 сая төгрөгийн авлагатай байснаас тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагуудаас 289.0 сая төгрөг байгууллагын дансанд орж, 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 513.3 сая төгрөгийн авлагатай байна.

Байгууллагын өр авлагыг барагдуулах зорилгоор 3 чиглэлийн 19 ажил бүхий төлөвлөгөөг боловсруулж, Газрын даргаар батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласнаар 2025 оны 12 дугаар сарын 08-ний өдрийн байдлаар 16 ажил 100%, 1 ажил 40%, 1 ажил 50%, 1 ажил 70% дундаж хэрэгжилт 93%-тай байна.

3.2. Санхүүгийн хяналт, аудитын дүгнэлт

Нийслэл дэх төрийн аудитын газрын 2024 оны санхүүгийн шалгалтаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын дагуу хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Нийслэл дэх төрийн аудитын газраас төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан шалгалтаас өгөгдсөн зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Нийслэлийн Дотоод аудитын албанаас байгууллагын 2023 он, 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтын зөвлөмжийн дагуу хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Улсын их хурлын байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоолын дагуу “Ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөө” сэдэвт аудитыг Үндэсний аудитын газраас 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн манай байгууллагад хийсэн. Уг аудитад шаардлагатай ус хангамж, ариутгах татуургын системийн мэдээлэл, цэвэр, бохир усны чанарын хяналт, байгууллагад 2020 оноос хойш хэрэгжсэн болон одоо хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг гарган өгч хамтран ажилласан. Аудитын тайлан, дүгнэлт хараахан баталгаажиж ирээгүй байна.

Тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4503 ширхэг 145096.4 сая төгрөгийн, зарлагын 760 ширхэг 122988.7 сая төгрөгийн гүйлгээ гарсныг шилэн дансны сайтад байршуулан ажиллалаа.

Цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ тарифыг нэмэгдүүлэх тооцоо судалгааг Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороонд 2025 оны 03 сарын 26-ны 4/563 тоот албан бичгээр, тарифын зохицуулалтыг шийдвэрлэхийг хүссэн албан бичгийг дахин 04 дүгээр сарын 28-ны өдрийн 4/1087 тоот албан бичгээр, тариф нэмэгдүүлэх саналыг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 2/3027 тоот бичгээр тус тус хүргүүлэн шийдвэрлэх хурал 2025 оны 12 дугаар сарын 04-нд Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороон дээр зохион байгуулсан.

Мөн Нийслэлийн засаг даргын тамгын газарт байгууллагын санхүү, эдийн засгийн тооцоо судалгаа, усны үйлчилгээний тарифыг шийдвэрлэхэд дэмжлэг хүсэх талаар 2025 оны 05 дугаар сарын 28-ний 4/1644 тоот албан бичгийг цахимаар илгээсэн.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ

2025 онд “Менежментийн тогтолцооны стандартуудыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх магадлан итгэмжлүүлэх” зорилтын хүрээнд хүний нөөцтэй холбоотой 5 ажлыг төлөвлөж, 100%-тай хэрэгжүүлэн ажиллалаа.

4.1. Бүтэц бүрэлдэхүүн

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/320 дугаар захирамжаар байгууллагыг зохион байгуулалтын 26 нэгжтэй, орон тооны дээд хязгаарыг 1943 ажилтантай байхаар шинэчлэн баталсан.

Шинэ цэвэрлэх байгууламж, Ус дахин боловсруулах үйлдвэр, Баруун доод эх үүсвэр болон Үйлдвэрийн бохирдлын хяналтын лаборатори зэрэг 4 шинэ объектыг 2025 онд ашиглалтад оруулахтай холбогдуулан 117 орон тоог шинээр нэмэгдүүлж, 3 зохион байгуулалтын нэгж, 1 алба шинээр байгуулж, 1 нэгжийн үйл ажиллагааг өргөтгөн алба болгож, 1 товчоог цомхотгохоор төлөвлөж гүйцэтгэлийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд орон тооны гүйцэтгэл 1766 ажилтан ажиллаж, хүний нөөцийн бүрдүүлэлт 90.9 хувь байна. Энэ онд шинэ бүтээн байгуулалтын хүрээнд шинээр ашиглалтад орох:

Шинэ цэвэрлэх байгууламж /37/

Ус дахин боловсруулах үйлдвэр /48/

Үйлдвэрийн бохирдлын хяналтын лаборатори /16/

Баруун доод эх үүсвэр /32/ байгууламжууд төлөвлөсөн хугацаанд үйл ажиллагаа эхлээгүйтэй холбоотойгоор орон тоо хэмнэж ажиллаж байна.

Хүний нөөцийн хөдөлгөөнийг тайлант хугацааны байдлаар гаргахад 138 ажилтантай хөдөлмөр эрхлэлтийн харилцааг үүсгэж, 131 ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцалсан байна.

Байгууллагын хэмжээний 422 ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Газрын даргын 06 дугаар сарын 16-ны өдрийн А/168 дугаар тушаалаар, Албан тушаалын жагсаалт болон Түлхүүр албан тушаалын жагсаалтыг шинэчлэн Газрын даргын 08 дугаар сарын 22-ны өдрийн А/211 дүгээр тушаалаар тус тус баталгаажуулсан.

Тайлант хугацаанд хөдөлмөрийн хугацаагүй гэрээ байгуулсан 1655, хөдөлмөрийн хугацаатай гэрээ байгуулсан 44 хөдөлмөрийн туршилтын гэрээ байгуулсан 67 ажилтан тус тус байна.

Байгууллагын даргын 2024 оны үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан А тушаал 321, хүний нөөцийн чиглэлээр гарсан Б тушаал 1264, нийт 1585 тушаалыг Archiv.edoc программд шивж оруулан Нийслэлийн Архивын газарт баримт хүлээн авсан 129 дүгээр актаар хүлээлгэн өгсөн.



Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага "MNS:6395:2022" стандартын дагуу нийтлэг 12 төрлийн

баримтуудаас Газрын Даргын Тушаал, Албан бичгийг хос бичгээр хөтлөн явуулж байна. Үүнд:

- Байгууллагаас гадагш явуулсан 3664 албан бичгээс 2518 бичгийг Монгол бичгээр хөрвүүлэн, дугаарлаж, хэвлэж илгээсэн.
- Газрын Даргын 2025 оны 01-10 сарын Хүний нөөцийн чиглэлээр болон үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан нийт 1056 тушаалыг Монгол бичгээр хөрвүүлэн, дугаар олгож бэлтгэсэн.

4.2 Сургалт, чадавхжуулалт

Газрын даргаар баталгаажуулсан 2025 оны 10 сарын 20-ны өдрийн УСУГ-АҮ-2025-51 тоот гэрээний дагуу байгууллагын нийт удирдах ажилтан, инженер техникийн ажилтан, албан хаагчдын мэргэжлийн мэдлэгийг үнэлэх ажлыг 11 дүгээр сарын 27, 28, 12 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулсан. Шалгалтад нийт ажилтнуудыг 13 бүлэгт хувааж 97% ирцтэйгээр 420 ажилтан хамрагдсан.

Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах үйл ажиллагааг Сургалт судалгааны төв болон зохион байгуулалтын нэгжүүдтэй хамтран зохион байгуулсан.

Энэ оны төлөвлөгөөнд тусгагдсан гадны байгууллага болон бусад алба хэлтэстэй хамтран 94 удаагийн, сургалт зохион байгуулахаас 71 сургалт зохион байгуулж 75.5 хувийн биелэлттэй байна.

Шинээр ажилд орж байгаа ажилтнуудын сургалтыг Газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/205 тушаал, хөтөлбөрийн дагуу зохион байгуулж нийт 12 зохион байгуулалтын нэгжийн 75 ажилтан хамрагдлаа.

Нийслэлийн засаг даргын тамгын газрын сургалтын төвөөс зохион байгуулж буй 12 төрлийн сургалтад давхардсан тоогоор 21 ажилтан, ХАБЭА-н чиглэлээр нийт 11 төрлийн сургалтад 632 ажилтан хамрагдсан.

Авилгатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн цахим сургалтад байгууллагын бүх цэг салбар, зохион байгуулалтын нэгжүүдийн 120 ажилтан алба хаагчийг хамрууллаа.

4.3 Хөдөлмөрийн сахилга, шагнал урамшуулал

2025 онд хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд ёс зүй, авилгын эсрэг, хөдөлмөрийн сахилгыг хангуулах чиглэлээр 7 ажлыг төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

Байгууллагын хэмжээнд энэ онд 5 журам, 1 дүрэм шинэчлэн батлуулсан.

Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн, хөдөлмөрийн гэрээний үүргээ биелүүлээгүй хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан 19 ажилтанг ажлаас халах, 34 ажилтанд сахилгын арга хэмжээ, нийт 53 ажилтанд хариуцлага тооцсон.

Ёс зүйн дэд хорооноос 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан Ёс зүйн өдөрлөг, Нөлөөллийн аяны хүрээнд Талархал, Уучлал, Ойлголцол, Санал бодол, шүүмжлэл, зөвлөгөөг хүндэтгэн хүлээн авах, Дэлхийн Ёс зүйн өдөр болон Бие биедээ анхаарал хандуулах өдрүүдийг нийт зохион байгуулалтын нэгж бүрд тус тус зохион байгуулж, тайлан, мэдээллийг байгууллагын дотоод фейсбүүкт байршуулан ажиллалаа. Ёс зүйн дэд хорооноос 4 төрлийн видео танилцуулга, мэдээллийн баннерыг бэлтгэн, ёс зүйн өдөрлөгийн үеэр ажилтнуудад үзүүлж, ёс зүйн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэн ажилласан.

Ёс зүйн дэд хороонд ирсэн 4 өргөдлийг судлан шийдвэрлэж, 5 ажилтан, 1 зохион байгуулалтын нэгжид зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.



Нийслэлийн засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/921 дугаар захирамжаар манай байгууллагыг 2024 оны эдийн засаг санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтод түвшинг бүрэн хангалттай биелүүлсэн гэж үнэлсэн.

Монгол улсын орон сууц нийтийн аж ахуйн салбарын хөгжил дэвшил иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж, ажлын амжилтаар тэргүүлж 2024 оны шилдэг байгууллагаар шалгарлаа.

Байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан 49 ажилтныг Төрийн одон медалиар, яамдын шагналаар 265, нийслэлийн шагналаар 35 ажилтан, байгууллагын шагналаар 12 ажилтан, нийт 361 ажилтан тус тус шагнагдсан.

ТАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ

5.1 Усны эх үүсвэрийн хамгаалалт

Ус хангамжийн Дээд эх үүсвэрийн хамгаалалтыг Дотоодын цэргийн 836 дугаар тусгай салбар, Багахангай эх үүсвэрийн хамгаалалтыг Дотоодын цэргийн 824 дугаар тусгай салбар, бусад эх үүсвэрийн хамгаалалтыг Дотоодын цэргийн 805 дугаар ангиудаар тус тус ундны усны аюулгүй байдлыг хамгаалах гэрээ байгуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд эх үүсвэр болон шугамын хамгаалалтын чиглэлээр албан бичгээр мэдэгдэл-28, эх үүсвэрийн чиглэлээр албан бичиг-7, санал-2, шугамын тодруулга-1, тайлан-1, шүүхэд тодруулга-2, хүсэлт-2, нийт 43 албан бичиг хүргүүлж ажилласан.

5.2 Байгаль орчны нөхөн сэргээлт

2025 онд “Менежментийн тогтолцооны стандартуудыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх магадлан итгэмжлүүлэх” зорилтын хүрээнд байгаль орчны менежментийн тогтоолцоог нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 1 ажлыг төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

Байгаль орчны менежментийн MNS ISO 14001 стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх Байгаль орчинтой холбогдох нийт 6 хууль, 5 журмаар нийцэл хийж, үл нийцлийг залруулах ажлын төлөвлөгөөнүүдийг Газрын даргын 2025.05.26-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

5.3 ХАБЭА-н хэрэгжилт, осолгүй ажилласан хугацаа

ХАБЭА-н үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 55 ажил тусгагдсанаас 50 ажил бүрэн хийгдэж, биелэлт 90.9%-тай байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үйл ажиллагааны зардалд 1794.2 сая.төгрөг төлөвлөснөөс 1447.6 сая төгрөг, цэвэрлэгээний зардалд 144.8 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 125.4 сая төгрөгийг зарцуулан ажиллалаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн соёлыг төлөвшүүлэх зорилгоор 2025 оны ХАБЭА-н сарын аяныг “Хандлагаа өөрчилье, дадлаа хэвшүүлье” уриан доор зохион байгуулахаар төлөвлөж, 8 ажил бүхий төлөвлөгөө батлуулсан бөгөөд 100% хэрэгжүүлэн ажиллалаа.

“ХАБЭА-н мэдлэгийг сорих асуулт, хариулт”-ын сугалаат уралдаан, “Ажиллах зөвшөөрлийг хэн хамгийн сайн өгдөг вэ?” уралдаан, “ХАБЭА-н мэдлэг чадвартай ажилтан шалгаруулах” тэмцээн болон “5Z соёлын хэрэгжилтийг сайжруулах” 5 тэг соёлын туг аялуулах зэрэг 4 төрлийн идэвхжүүлэх арга хэмжээний ажлыг төлөвлөсөн.



“Үерийн гамшгийн үеийн харилцан ажиллагаа, бэлтгэл бэлэн байдлыг хангах” сэдэвт танхимын дадлага сургуулийг зохион байгуулж, нийт 45 ажилтан хамрагдсан. Гадна байгууллагаас ажиглагчаар Дотоодын цэргийн 805-р анги,

Нийслэлийн Онцгой байдлын Газар, Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-ын төлөөлөл оролцон зөвлөмж өгч ажилласан.



Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийн тогтолцооны MNS ISO 45001:2018 стандартын дотоод аудитыг зургаан зохион байгуулалтын нэгжид хийж гүйцэтгэлээ.

Байгууллагын ажлын тусгай хувцас, гутлын стандартыг ШУТИС-ийн Хувцас судлалын тэнхимтэй гэрээ байгуулж, Ус сувгийн удирдах газрын ажиллагсдын 14 төрлийн ажлын хувцасны техникийн шаардлага бүхий "Ажлын тусгай хувцсанд тавигдах ерөнхий шаардлага CS 11-0605:2025", "Ус сувгийн удирдах газрын ажиллагсдын ажлын тусгай гуталд тавигдах ерөнхий шаардлага CS 11-0606:2025" тус тус байгууллагын 2 төрлийн байгууллагын стандартыг батлуулан ажиллалаа.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ИРЭЭДҮЙН ЗОРИЛТ, ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Тайлант хугацаанд хэрэгжилт хангагдаагүй зорилтуудын шалтгаан

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан Туул усан цогцолборын ТЭЗҮ шинэчлэх, “Толгойт” коллекторын 2 дугаар ээлжийг ашиглалтад оруулах ажлын хугацаа хойшилсон тул үнэлэх боломжгүй байна.

Түлхүүр 20 гүйцэтгэлийн үзүүлэлтээс 1 үзүүлэлт (21.Бохир усны цэвэрлэгээг стандарт MNS 4943:2015-тай харьцуулснаар) улаан гэрэл, 1 үзүүлэлт (1.Олборлож байгаа усны хэмжээг тогтоосон нөөцтэй харьцуулах) шар гэрэл ассан нь цаашид анхаарал хандуулж, сайжруулах арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

6.2. Шинэ санаачилга, төсөл хөтөлбөр

Шинээр ашиглалтад орж буй Баруун эх үүсвэр, Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр, Шинэ төв цэвэрлэх байгууламжид хэрэглэх 24 нэр төрлийн химийн бодисыг импортлох, ашиглах тусгай зөвшөөрлийг авснаар дээрх шинэ байгууламжуудын туршилт, тохируулгад ашиглах химийн бодисын нийлүүлэлт тасралтгүй хийгдэх боломж бий болсон.

2025 оныг “Хаягдал усны бохирдол бууруулах жил” болгон зарлаж, “Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлье” уриалгыг дэвшүүлж, 38 төрлийн видео шторкийг олон нийтэд түгээж, “Суултуур хогийн сав биш” сэдэвт зурагт хуудсыг томоохон аж ахуйн нэгжийн ариун цэврийн өрөөнд байршуулан ажиллалаа.

Ундны усны чанар, аюулгүй байдалд хяналт шинжилгээ хийсэн лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн “Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт түгээж буй ундны усны чанар” сэдэвт видео бичлэг хийж, олон нийтэд түгээж ажиллалаа.

Гэр хорооллын иргэдэд ус түгээх байрнаас ус авахдаа усаа асгахгүй байхыг уриалсан агуулга бүхий 1 видео бичлэг, “Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлье” аянд нэгдэн 1 видео бичлэг, “1 литр усны үнэ хэд вэ?” сэдэвт шторк хийж, олон нийтэд түгээлээ.

Хяналт удирдлагын төвийн хэрэглэгчдээс дуудлага хүлээн авах үйл ажиллагааг Call center-ийн хэлбэрт оруулан шинэ системийг нэвтрүүлж байгууллагын нийт үйлчилгээ үзүүлдэг зохион байгуулалтын нэгжүүдийг 18001313 дугаарт холбон хэрэглэгчийн дуудлага, санал хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх, санал хүсэлт барагдуулалтын гүйцэтгэлд үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ иргэд олон нийтэд энэхүү дугаарыг таниулах ажлын төлөвлөгөөг гарган амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.



Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг ЗТ-4.4, Барилга байгууламжийн ажлын төсөв ЗТ-10.2 хийх тусгай зөвшөөрлийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 107 дугаар тушаалаар 5 жилийн хугацаатай авч, Монголын барилгын үндэсний ассоциатай гэрээ байгуулан ажиллаж байна.

Шинэ Төв цэвэрлэх байгууламжийн барилга бүтээцийн ажил 98%, тоног төхөөрөмж суурилуулах ажил 97%, технологийн 35 төрлийн 55 барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажил 98%-тай үргэлжилж, 2025 оны 07 дугаар сарын 24-ны өдрөөс эхлэн ус хүлээн авч туршилт тохируулгын ажил эхэлсэн ба хүлээн авах техникийн комисс ажиллалаа.



Баруун эх үүсвэрийн ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилгын угсралтын ажил 97%, урвуу осмос, цэвэршүүлсэн усны сан, насос станц, хаягдал боловсруулах хэсэг, цахилгааны болон харуулын байрны барилга угсралтын ажлууд 100%-ийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд Биокомбинатын долоон худгуудын шугамын холболтын

хаалт тоног төхөөрөмжийн ажлууд дууссан цахилгааны шит болон удирдлагын Scada системийн холболтын ажлууд 14 гүний худгаас 11 худгийн холболт хийгдэн 80% гүйцэтгэлтэй байна.

Ус дахин боловсруулах үйлдвэрийн техникийн комисст байгууллагаас 5 ажилтан томилогдон ажилласан. Нийт 9 үндэс хэсэгт туршилт тохируулга хийгдэж бактери үржүүлэх ажил хийгдэж байна Одоогийн байдлаар удирдлагын төвүүд бүрэн хүчдэлээ авч төхөөрөмжүүдийг турших шалгах ажлууд хийгдэж байна.



Ус ашиглалтын байгууллагуудын түншлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Нидерланд улсын ВЭИ компанийн 11 мэргэжилтэн өөрсдийн чиглэлийн хүрээнд байгууллагын инженер техникийн ажилтнуудтай багаараа хамтран ажилласан бөгөөд МСС, ВЭИ, УСУГ-ын хамтарсан дүгнэх уулзалтад ВЭИ компанийн мэргэжилтнүүд болон УСУГ-ын багийн ахлагч нар оролцон ажлын тайланг хэлэлцлээ.



Баруун эх үүсвэр болон Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр, Шинэ цэвэрлэх байгууламж зэрэг шинээр хүлээн авах болон одоогийн ашиглаж буй хөрөнгүүдийн ашиглалт, үйл ажиллагааг урт хугацаанд хэвийн, найдвартай, тасралтгүй, үр ашигтайгаар явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын МСС-гаас хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газрын хөрөнгийн менежментийн техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээ”-ний төслийг Франц Улсын Сэурика компани гүйцэтгэн ажиллаж байна.

Байгууллагын зүгээс төслийг хэрэгжүүлэх хугацаанд байгууллагын хөрөнгийн менежментийн цаашдын зорилт, стратегийн талаар санал болон шийдвэр гаргах Удирдах хороо болон төслийн ажлыг дэмжих, өдөр тутмын харилцаа холбоог хариуцах, төслийн явцад дэмжлэг үзүүлэх зорилгоор техникийн Ажлыг хэсгийг газрын даргын тушаалаар баталсан.

Тус төсөл нь Байгууллагад менежментийн тогтолцоог нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, Хөрөнгийн менежментийн бодлогын баримт бичиг боловсруулах, Хөрөнгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, Хөрөнгийн менежментийн программ (CMMS)-ыг нэвтрүүлэх гэсэн 4 үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжиж байна. Үүнд:

Техникийн туслалцаа үзүүлэх буюу Хөрөнгийн менежментийн программ (CMMS)-ыг байгууллагад нэвтрүүлэх ажлын хүрээнд Sevico олон улсын байгууллагын Bluebee smart O&M программ шалгарч, программын функцүүд болон өдөр тутмын ашиглалт, засвар үйлчилгээ (O&M)-ний үйл ажиллагаанд программыг хэрхэн ашиглах талаар хамтарсан ажлуудыг эхлүүлэхээр төлөвлөсөн.



Мөн тухайн программыг байгууллагад нэвтрүүлэх, ашиглахад шаардлагатай менежментийн тогтолцооны тухай ойлголт, хөрөнгийн бүртгэл, ашиглалтын талаарх дүн шинжилгээ, зөвлөмжүүд өгөх, бэлтгэл ажлыг хангах зорилгоор дээрх эхний 3 үндсэн чиглэлээр ажлуудыг зохион байгуулан ажилласан.

Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн II Компакт гэрээний буюу Усны Компактын гурван гол төслийн нэг Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд нийслэлийн зургаан дүүргийн гэр хорооллын шугамд холбогдсон 180 ус түгээх байрыг бүрэн автомат ажиллагаанд оруулж иргэдэд 24 цагийн тасралтгүй үйл ажиллагаатай болсон.



Токиогийн ариутгах татуургын корпорацийн төслийн багийн гишүүдтэй хамтран 2025 оны төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулан ажилласнаар 2 сард 6 ажилтан, 10 сард 7 ажилтан Япон улсын Токио болон Сузука хотод сургалтад хамрагдаж, 10 удаагийн онлайн уулзалтыг хийж, ГМС-ийн өргөтгөл шинэчлэлтийн ажил хийгдсэн

Токио хотын захиргаа болон TGS компанийн 11 мэргэжилтэн 7 сарын 16-23-ны өдрүүдэд монгол улсад ирж, хөтөлбөрийн дагуу Бохир усны шугам сүлжээнд камерын оношилгоог хэрхэн хийдэг талаарх танхимын сургалтыг явуулж, сургалтад

УСУГ-аас 13 ажилтан оролцлоо. Мэдээллийн систем хариуцсан ахлах мэргэжилтэн Япон улсад шугам хоолойн үзлэг шалгалт, хяналтыг хэрхэн хийдэг, бохир усны шугамыг доторлох аргачлал, хоолойн гэмтлийн зэргээс нь хамаарч эрэмбэлэх сургалтыг инженер техникийн ажилтнууд болон засварчдыг сургалтад хамруулсан.



Япон улсын элчин сайдын яамнаас 2025 оны 4 сард гаргасан хүсэлтийн дагуу тус улсаас ирсэн 3 удаагийн 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэгтэй хамтран бэлтгэл ажлыг хангаж ажилласны үр дүнд Япон Улсын Цог Жавхлант Эзэн Хаан Нарүхито 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдөр зочилж, байгууллагын Хяналт удирдлагын төв болон Гачууртын эх үүсвэрийн үйл ажиллагаатай танилцлаа.



БНСУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдах зөөврийн бохир ус юүлэх, урьдчилан цэвэрлэх байгууламжийг Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт барихаар шийдвэрлэж байгууламжийн загвар зургийг батлуулан ажиллалаа.

Цэвэрлэх байгууламжийн лаг хатаах, шатаах байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтыг зарлаж Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан ажиллалаа.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ

7.1 Тайлант хугацааны үнэлгээ


1. Монгол улсын Засгийн газар болон АНУ, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр баригдаж буй ус хангамжийн Баруун эх үүсвэр, Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр, Шинэ төв цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг хүлээн авах бэлтгэлийг ханган ажиллалаа.

2. Нийслэлийн хэрэглэгчдийг цэвэр усаар тасралтгүй хангах, бохир усыг татан зайлуулж цэвэрлэн байгальд нийлүүлэх, чанар стандартыг мөрдөн, дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор хийсэн ажлын үр дүнд ахиц дэвшил гарган 2025 онд дэвшүүлсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлэн 100 хувь биелүүлэн ажиллалаа.

7.2 2025 оны гол зорилтууд

- ✓ Байгууллагын 2021 онд батлан гаргасан “Тогтвортой Хөгжлийн Стратеги 2030” бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн батлах,
- ✓ Баруун эх үүсвэр, Ус дахин цэвэршүүлэх үйлдвэр, Шинэ цэвэрлэх байгууламжийн төслүүдийн туршилт тохируулгын ажил гүйцэтгэхэд хамтран ажиллах, хүлээн авах,
- ✓ Байгууллагын эдийн засаг, санхүүгийн чадавхыг сайжруулах ажлын хүрээнд Мянганы Сорилтын сангаас хэрэгжүүлж байгаа төслөөс баталсан Усны салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангах “Зардал Нөхөх” төлөвлөгөөг хэрэгжүүлэн үр ашигтай ажиллах.
- ✓ Аюулгүй ажиллагааны зөв зан үйл, хандлагыг хэвшүүлэн, ажилтны оролцоо, зөвлөгөөн, хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоог сайжруулах замаар MNS ISO 45001:2018 стандартын хэрэгжилтийг хангах үр дүн гаргах.

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН
ДАРГА



Ц.ТӨРХҮҮ

ХЯНАСАН:
ИНЖЕНЕРИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ОДХҮҮ

НЭГТГЭСЭН:
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ИНЖЕНЕР
ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ИНЖЕНЕР

Д. Болормаа Д.БОЛОРМАА

Ж.БАТЖАРГАЛ